

3.1 Хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын байдал, нас, хүйсээр

Монгол Улсын хүн ам, орон сууцны бараг бүх тооллогод хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын холбогдох асуулт орж байсны дотор сүүлчийн тооллогуудад энэ талаарх асуултын ойлголт, тодорхойлолт ойролцоо байсан. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого бүхэлдээ олон улсын нийтлэг арга зүйгээр явагдсан. Гэхдээ хүн амын боловсрол, бичиг үсгийн мэдлэгийн холбогдох ойлголт, тодорхойлолт ижил байсан гэж үзэх үндэстэй. Харин 2000 оны тооллогын дүнд өмнөх тооллогод байсан зарим нэг боловсролын түвшинг нэгтгэж, өмнөх тооллогуудын дүнтэй зэрэгцүүлсэн юм.

Манай улс 1921 оноос ард иргэдийнхээ бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах зорилтыг төр, засгаас дэвшүүлж, энэ ажлын хүрээнд сургуулийн насны хүүхдийг сургуульд бүрэн хамруулах, улмаар боловсролыг шат дараалан зохих насанд нь эзэмшүүлэх, насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах талаар төр, засгаас олон төрлийн арга хэмжээ авсны дүнд бүр 1960-аад он гэхэд ард иргэдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг үндсэнд нь арилгасан тухайн үеийн цөөн орнуудын тоонд орсон билээ.

Боловсрол бол хүний хөгжлийг тодорхойлогч цогц үзүүлэлт, улс орны хүн хөгжил чадавхийг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг билээ. Судалгааны энэ бүлэгт тус улсын хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшний 20 гаруй жилийн өөрчлөлтийг үзүүлэх болно.

Бичиг үсгийн мэдлэг (Бичиг үсгийн мэдлэгийн талаарх ойлголт, тодорхойлолтыг судалгааны 1 дүгээр бүлгээс үзнэ үү). Олон улсын нийтлэг жишиг аргачлалаар хүн амын бичиг үсгийн мэдлэгийг 15, түүнээс дээш насанд тодорхойлдог. Тус улсын 15, түүнээс дээших насны нийт хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшний сүүлийн 20 гаруй жилийн өөрчлөлтийг хүснэгт 3.1-ээс үзэж болно.

Хүснэгт 3.1 Арван тав, түүнээс дээш настай нийт хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, хүйс, хувиар, 1979, 1989, 2000 он

| Хүйс | Бичиг үсэг мэддэггүй | Бичиг үсэг мэддэг боловч боловсролгүй | Бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд, техник мэргэжил | ТМД дунд, бүрэн бус дээд | Дээд |
|----------------------------|----------------------|---------------------------------------|------|----------------|-----------------------------|--------------------------|------|
| 1979 он¹ | | | | | | | |
| Бүгд | 7.3 | 11.4 | 29.0 | 28.4 | 9.8 | 7.9 | 6.2 |
| Эрэгтэй | 3.9 | 11.6 | 28.8 | 32.5 | 9.2 | 6.6 | 7.4 |
| Эмэгтэй | 10.6 | 11.3 | 29.1 | 24.3 | 10.4 | 9.3 | 5.0 |
| 1989 он¹ | | | | | | | |
| Бүгд | 3.5 | 6.0 | 20.5 | 33.9 | 18.1 | 9.6 | 8.5 |
| Эрэгтэй | 1.8 | 5.0 | 19.7 | 38.8 | 17.6 | 7.4 | 9.8 |
| Эмэгтэй | 5.1 | 7.0 | 21.4 | 29.0 | 18.6 | 11.7 | 7.2 |
| 2000 он | | | | | | | |
| Бүгд | 2.2 | 3.2 | 16.4 | 30.1 | 29.7 | 9.2 | 9.2 |
| Эрэгтэй | 2.0 | 3.1 | 17 | 34 | 27.8 | 6.9 | 9.2 |
| Эмэгтэй | 2.5 | 3.4 | 15.8 | 26.2 | 31.6 | 11.3 | 9.2 |

¹ 1979, 1989 онд техник мэргэжлийн боловсролыг тусад нь аваагүй

Монгол Улсад бичиг үсэг үл мэддэг хүний эзлэх хувь сүүлийн 20 гаруй жилд 8.2 пунктээр буурсан боловч анхаарах асуудал бас байгааг хүснэгт 3.2-оос харж болох байна.

Хүснэгт 3.2 Арван тав, түүнээс дээш настай хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр, 2000 он

| Насны бүлэг | Бичиг үсэг мэддэггүй | Бичиг үсэг мэддэг боловч боловсрол-гүй | | | Бүрэн бус дунд | Бүрэн дунд, техник мэргэжил | ТМД дунд, бүрэн бус дээд | Дээд | Бүгд | |
|----------------|----------------------|--|-----------|------|----------------|-----------------------------|--------------------------|-------|---------|--------------|
| | | Бага | Бүрэн бус | Бага | | | | | хувь | хүн амын тоо |
| Бүгд | | | | | | | | | | |
| Бүгд | 2.2 | 3.2 | 16.4 | 30.1 | 29.7 | 9.2 | 9.2 | 100.0 | 1524372 | |
| 15-19 | 3.2 | 4.5 | 28.3 | 37.3 | 26.7 | - | - | 100.0 | 263358 | |
| 20-24 | 1.3 | 1.4 | 12.2 | 36.1 | 38.3 | 4.4 | 6.3 | 100.0 | 235751 | |
| 25-29 | 1.0 | 0.8 | 4.1 | 32 | 42.3 | 10.5 | 9.3 | 100.0 | 216652 | |
| 30-34 | 1.2 | 1.0 | 4.4 | 29.5 | 39.7 | 13.6 | 10.6 | 100.0 | 187872 | |
| 35-39 | 1.3 | 1.3 | 7.4 | 29.1 | 32.3 | 14.1 | 14.5 | 100.0 | 172606 | |
| 40-44 | 0.9 | 1.4 | 12.6 | 31.1 | 23.8 | 15.0 | 15.2 | 100.0 | 127220 | |
| 45-49 | 1.1 | 1.7 | 18.7 | 26.7 | 20.3 | 16.1 | 15.4 | 100.0 | 82888 | |
| 50-54 | 1.3 | 2.4 | 23.8 | 22.1 | 17.0 | 15.7 | 17.7 | 100.0 | 57835 | |
| 55-59 | 2.5 | 5.3 | 33.7 | 19.3 | 11.9 | 12.2 | 15.1 | 100.0 | 55895 | |
| 60 + | 9.2 | 16.6 | 41.8 | 12.1 | 5.9 | 6.7 | 7.7 | 100.0 | 124295 | |
| Эрэгтэй | | | | | | | | | | |
| Бүгд | 2.0 | 3.1 | 17 | 34.0 | 27.8 | 6.9 | 9.2 | 100.0 | 749890 | |
| 15-19 | 4.3 | 5.7 | 32 | 36.5 | 21.5 | - | - | 100.0 | 133327 | |
| 20-24 | 1.6 | 1.9 | 16.7 | 40.1 | 32.6 | 2.8 | 4.3 | 100.0 | 118023 | |
| 25-29 | 1.2 | 1.0 | 5.4 | 38.3 | 39.7 | 7.0 | 7.4 | 100.0 | 107962 | |
| 30-34 | 1.3 | 1.2 | 5.5 | 35.7 | 37.7 | 9.4 | 9.2 | 100.0 | 92473 | |
| 35-39 | 1.3 | 1.5 | 8 | 35.0 | 31.2 | 9.8 | 13.2 | 100.0 | 84846 | |
| 40-44 | 0.9 | 1.4 | 12.4 | 35.8 | 24.4 | 10.2 | 14.9 | 100.0 | 62619 | |
| 45-49 | 1.0 | 1.4 | 16.5 | 29.6 | 21.5 | 12.4 | 17.6 | 100.0 | 40562 | |
| 50-54 | 1.0 | 1.9 | 19 | 23.7 | 18.7 | 13.3 | 22.4 | 100.0 | 27707 | |
| 55-59 | 1.5 | 3.6 | 26.3 | 21.0 | 13.5 | 12.8 | 21.3 | 100.0 | 27379 | |
| 60 + | 3.7 | 12.7 | 37.2 | 15.6 | 8.0 | 9.2 | 13.6 | 100.0 | 54992 | |
| Эмэгтэй | | | | | | | | | | |
| Бүгд | 2.5 | 3.4 | 15.8 | 26.2 | 31.6 | 11.3 | 9.2 | 100.0 | 774482 | |
| 15-19 | 2.1 | 3.2 | 24.5 | 38.1 | 32.1 | - | - | 100.0 | 130031 | |
| 20-24 | 1.0 | 0.9 | 7.7 | 32.1 | 44.0 | 6.0 | 8.3 | 100.0 | 117728 | |
| 25-29 | 0.9 | 0.6 | 2.9 | 25.6 | 44.8 | 14.0 | 11.2 | 100.0 | 108690 | |
| 30-34 | 1.1 | 0.8 | 3.4 | 23.6 | 41.6 | 17.6 | 11.9 | 100.0 | 95399 | |
| 35-39 | 1.3 | 1.2 | 6.9 | 23.3 | 33.3 | 18.2 | 15.8 | 100.0 | 87760 | |
| 40-44 | 1.0 | 1.3 | 12.9 | 26.6 | 23.2 | 19.6 | 15.4 | 100.0 | 64601 | |
| 45-49 | 1.3 | 1.9 | 20.8 | 23.9 | 19.1 | 19.7 | 13.3 | 100.0 | 42326 | |
| 50-54 | 1.6 | 3.0 | 28.1 | 20.5 | 15.6 | 17.8 | 13.4 | 100.0 | 30128 | |
| 55-59 | 3.5 | 7.0 | 40.6 | 17.6 | 10.4 | 11.7 | 9.2 | 100.0 | 28516 | |
| 60 + | 13.7 | 19.7 | 45.5 | 9.2 | 4.2 | 4.6 | 3.1 | 100.0 | 69303 | |


Хүн амаа бичиг үсэгт сургах талаар олон жилийн өмнөөс явуулсан арга хэмжээний үр дүнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын зөвхөн 2.2 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байгаа нь багахан хэмжээ боловч нарийвчлан үзвэл анхаарах асуудал нэлээд байгаа нь 2000 оны тооллогын дүнгээс харагдаж байна. 15-19 насны хүүхэд, залуучуудын дотор бичиг үсэг үл мэдэгчдийн эзлэх хувь 2000 онд 1989 оныхоос 2.2 пунктээр өсчээ. Энэ онд 15-19 насны хүүхэд, залуучуудын 4.2 хувь буюу 8.4 мянган хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагийн 5.6 мянга нь эрэгтэйчүүд, 2.8 нь эмэгтэйчүүд байгаа нь судалгааны 2 дугаар бүлэгт тэмдэглэсэнчлэн хөвгүүд шинээр сургуульд элсэхдээ охидоосоо цөөн байгаа төдийгүй тэд сургуулиас илүү

олноороо завсардаж байгаагийн зэрэгцээ бүрэн дунд боловсрол эзэмшсэн байх насандаа бичиг үсэг мэдэхгүй байгаа нь анхаарал татаж байна. 1989 онд 20-29 насны залуучуудын 1.8 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байсан бол 2000 онд 2.3 хувь болж, нийт 5.3 мянган хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагийн 60.4 хувь нь мөн л эрэгтэйчүүд байна.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүйсийн тэгш байдлын талаар ихээхэн том зорилтууд дэвшүүлэн, олон хөтөлбөр боловсруулж байгаа өнөө үед суралцагчдын хүйсийн харьцааны тэнцвэрт байдлыг хангах талаар төр, засгаас анхаарах, хөвгүүд сургуульд элсэхдээ хойрогшиж, элссэн хойноо сургуулиас илүү олноороо завсардаж байгаагийн учир шалтгаан нь гагцхүү амьжиргааны түвшиний доройтолтой холбоотой юу эсвэл өөр учир шалтгаан байгаа эсэхийг судлаж, ойрын жилүүдэд шуурхай арга хэмжээ авахгүй бол залуучуудын ялангуяа эрэгтэйчүүдийн дотор бичиг үсэг үл мэдэх явдал газар авч болзошгүй байгааг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага анхаарах цаг болсон гэж үзэж байна.

Хүн амын боловсролын түвшин (Боловсролын талаарх ойлголт тодорхойлолтыг судалгааны 1 дүгээр бүлгээс үзнэ үү) Манай улсын хүн амын боловсролын түвшинд сүүлийн 20 гаруй жилд чанарын ахиц гарсан байна. 15, түүнээс дээш настай нийт хүн амд бага боловсролтой хүний эзлэх хувь 2000 онд 1979 оныхоос 12.6 пунктээр, 1989 оныхоос 4.1 пунктээр тус тус буурч, харин дээд боловсролтой хүний эзлэх хувь мөн хугацаанд 2.3, 0.7 пунктээр өссөн байна. 15, түүнээс дээш настай нийт эмэгтэйчүүдэд дээд боловсролтой хүний эзлэх хувийн жин 2000 онд 1979 оныхоос 4.2 пунктээр, 1989 оныхоос 2.0 пунктээр нэмэгдэж, эрэгтэйчүүдийнхтэй ижил хэмжээтэй болсон нь сүүлийн жилүүдэд манай эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрс дээшилж байгааг харуулж байна. Хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын байдлыг, насны бүлэг, хүйсээр 1979, 1989 оноор хавсралт 3.1,3.2-д дэлгэрэнгүй үзүүлэв.

Зураг 3.1 Арван таваас дээш настай боловсролтой хүн амын хүйсийн харьцаа, 1989, 2000 он



Бага боловсролтой хүн амын хүйсийн харьцаа нэмэгдэж, бусад боловсролтой хүн амын хүйсийн харьцаа буурч байгаагийн дотор дээд боловсролтой хүн амын хүйсийн харьцаа ихээхэн хурдацтай буюу 37.5 пунктээр буурсан байна. Мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэхдээ их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн дунд сургуульд суралцагчдын мэргэжлийн онцлогийг харгалзан тэдний хүйсийн харьцааг эдийн засгийн үйл ажиллагааны төрөл бүрийн салбарт шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээ шаардлагыг харгалзан төр, засгаас зохицуулах арга хэмжээг одооноос авахгүй бол ойрын жилүүдэд мэргэжилтэй боловсон хүчний хүйсийн харьцаа ихээхэн алдагдах төлөвтэй байна.

Арван тав, түүнээс дээш настай нийт хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувийн жинг харуулсан хүснэгт 3.2-оос тус улсын боловсролын хөгжлийн түүхэн онцлог байдлууд харагдаж байгаа юм. Тухайлбал 25-34 настай нийт хүн амын дотор бага боловсролтой хүн амын эзлэх хувийн жин 4.1-4.4 хувь байгаа нь 1970-1980-аад онд сургуулийн насны хүүхдийг бүрэн бус дунд боловсролтой болгох талаар дэвшүүлсэн зорилт амжилттай хэрэгжсэнийг харуулж байна. Харин 55-аас дээш настай 3 хүний нэг нь боловсролгүй, 2-3 хүний нэг нь бага боловсролтой байгаа нь 1950-иад он түүнээс өмнө тус улсын хүн амын боловсролын түгээмэл түвшин нь бага боловсрол байсантай холбоотой. 40-54 настай нийт хүний 15.2-17.7 хувь нь дээд боловсролтой байгаа нь 1960 оны сүүлчээс төрөл бүрийн мэргэжилтэй дээд боловсролтой боловсон хүчнийг олноор бэлтгэж, эдийн засгийн үйл ажиллагааны төрөл бүрийн салбарт ажиллуулж байсантай холбоотой. Гэтэл 1989 онд 25-29 настай залуучуудын 11.5 хувь нь дээд боловсролтой байсан бол 2000 онд мөн насны залуучуудын 9.3 хувь нь дээд боловсролтой байгаа нь тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж, дээд сургуулиуд зах зээлийн зарчмаар ажиллаж, төлбөртэй болсноос 1990-ээд оноос хойш 10 дугаар анги төгсөгчид дээд боловсрол эзэмших нь амьжиргааны түвшинтэй уялдан хязгаарлагдмал болсныг харуулж байна.

3.2 Хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, байршлаар

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор нийт хүн амын 56.6 хувь нь хотод, 43.4 хувь нь хөдөө байнга оршин сууж байсан. Хот, хөдөөгийн хүн амын амьдралын хэвшил, эрхэлдэг аж ахуй үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог болон сүүлийн жилүүдэд хөдөөнөөс хот уруу шилжих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор хот, хөдөөгийн хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшингийн ялгаа улам нэмэгдэх хандлагатай байна.

Арван тав, түүнээс дээш настай хөдөөгийн нийт хүн амд бичиг үсэг үл мэдэгчид болон боловсролгүй, бага, бүрэн бус дунд боловсролтой хүн амын эзлэх хувийн жин хотынхоос өндөр, бүрэн дундаас дээш боловсролтой хүн амын эзлэх хувийн жин хотынхоос бага байгаа нь хөдөөгийн хүн амын боловсролын ерөнхий түвшин хотынхоос доогуур байгааг харуулж байна.

Хүснэгт 3.3 Арван тав, түүнээс дээш настай хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, насны бүлэг, хүйс, байршлаар, 2000 он


| Насны бүлэг | Бичиг үсэг мэддэггүй | Бичиг үсэг мэддэг боловч боловсролгүй | | Бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд, техник мэргэжил | ТМД дунд, бүрэн бус дээд | Дээд | Бүгд | |
|--------------|----------------------|---------------------------------------|------|------|----------------|-----------------------------|--------------------------|-------|--------|--------------|
| | | Боловсролгүй | Бага | | | | | | хувь | хүн амын тоо |
| Хот | | | | | | | | | | |
| Бүгд | 1.1 | 1.7 | 8.7 | 25.8 | 37.3 | 11.4 | 14.0 | 100.0 | 898676 | |
| 15-24 | 1.0 | 1.2 | 11.6 | 33.3 | 45.4 | 2.9 | 4.6 | 100.0 | 289938 | |
| 25-34 | 0.5 | 0.4 | 1.3 | 21.7 | 46.0 | 14.6 | 15.4 | 100.0 | 239181 | |
| 35-54 | 0.5 | 0.7 | 4.6 | 24.3 | 30.2 | 17.6 | 22.0 | 100.0 | 273799 | |
| 55 + | 4.9 | 8.9 | 29.5 | 17.6 | 11.3 | 11.5 | 16.4 | 100.0 | 95758 | |
| Эрэгтэй | 1.0 | 1.4 | 8.4 | 30.3 | 36.1 | 8.7 | 14.1 | 100.0 | 433496 | |
| 15-24 | 1.4 | 1.7 | 14.0 | 37.5 | 40.1 | 2.0 | 3.2 | 100.0 | 141050 | |
| 25-34 | 0.6 | 0.6 | 1.7 | 27.3 | 46.4 | 10.4 | 13.1 | 100.0 | 115606 | |
| 35-54 | 0.5 | 0.6 | 4.2 | 28.7 | 30.3 | 13.0 | 22.6 | 100.0 | 133298 | |
| 55 + | 1.8 | 5.3 | 20.9 | 19.9 | 13.3 | 13.0 | 25.8 | 100.0 | 43542 | |
| Эмэгтэй | 1.3 | 1.9 | 8.9 | 21.6 | 38.5 | 13.9 | 14.0 | 100.0 | 465180 | |
| 15-24 | 0.6 | 0.8 | 9.3 | 29.3 | 50.4 | 3.7 | 5.9 | 100.0 | 148888 | |
| 25-34 | 0.4 | 0.4 | 1.0 | 16.5 | 45.7 | 18.5 | 17.5 | 100.0 | 123575 | |
| 35-54 | 0.5 | 0.7 | 5.0 | 20.1 | 30.2 | 22.0 | 21.5 | 100.0 | 140501 | |
| 55 + | 7.4 | 11.8 | 36.8 | 15.7 | 9.6 | 10.2 | 8.4 | 100.0 | 52216 | |
| Хөдөө | | | | | | | | | | |
| Бүгд | 3.8 | 5.5 | 27.5 | 36.2 | 18.9 | 5.9 | 2.3 | 100.0 | 625696 | |
| 15-24 | 4.1 | 5.5 | 33.3 | 41.4 | 13.9 | 1.0 | 0.7 | 100.0 | 209171 | |
| 25-34 | 2.0 | 1.6 | 8.5 | 44.0 | 33.9 | 8.1 | 2.0 | 100.0 | 165343 | |
| 35-54 | 2.2 | 3.0 | 27.3 | 34.9 | 17.9 | 10.5 | 4.2 | 100.0 | 166750 | |
| 55 + | 9.8 | 17.9 | 50.4 | 10.6 | 3.8 | 4.8 | 2.8 | 100.0 | 84432 | |
| Эрэгтэй | 3.4 | 5.4 | 28.8 | 39.2 | 16.6 | 4.3 | 2.4 | 100.0 | 316394 | |
| 15-24 | 5.0 | 6.8 | 38.6 | 39.1 | 9.6 | 0.4 | 0.4 | 100.0 | 110300 | |
| 25-34 | 2.1 | 1.8 | 10.4 | 50.4 | 28.5 | 5.0 | 1.7 | 100.0 | 84829 | |
| 35-54 | 2.1 | 2.9 | 25.4 | 39.3 | 18.5 | 7.3 | 4.5 | 100.0 | 82436 | |
| 55 + | 4.3 | 14.5 | 48.0 | 14.6 | 6.0 | 7.5 | 5.3 | 100.0 | 38829 | |
| Эмэгтэй | 4.2 | 5.6 | 26.1 | 33.1 | 21.3 | 7.6 | 2.1 | 100.0 | 309302 | |
| 15-24 | 3.0 | 4.1 | 27.4 | 44.1 | 18.8 | 1.6 | 1.0 | 100.0 | 98871 | |
| 25-34 | 1.8 | 1.3 | 6.4 | 37.2 | 39.6 | 11.3 | 2.4 | 100.0 | 80514 | |
| 35-54 | 2.4 | 3.1 | 29.2 | 30.5 | 17.3 | 13.6 | 3.9 | 100.0 | 84314 | |
| 55 + | 14.4 | 20.8 | 52.5 | 7.1 | 1.8 | 2.5 | 0.8 | 100.0 | 45603 | |

Арван тав, түүнээс дээш настай хөдөөгийн нийт хүн амд боловсролгүй хүн амын эзлэх хувийн жин хотынхоос 6.5 пунктээр, бага боловсролтой хүн амынх 18.8 пунктээр, бүрэн бус дунд боловсролтой хүн амынх 10.4 пунктээр тус тус өндөр, харин тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд боловсролтой хүн амынх 5.5 пунктээр, дээд боловсролтой хүн амын 11.7 пунктээр доогуур байна. Олон улсын нийтлэг жишиг хандлага, үүний дотор хөгжиж байгаа орнуудын хөдөөгийн хүн амын боловсролын түвшин хотынхоос доогуур байдаг жишиг манайд ч мөн хадгалагдаж байна. Манай улсын эдийн засаг, нийгмийн амьдралд сүүлийн 11 жилд гарсан өөрчлөлтүүд үүний дотор хөдөө аж ахуйн нэгдэл задарч, мал хувьчлагдаж, газар тариалангийн үйлдвэрлэл уналтад орсон зэрэг нь хөдөө орон нутагт ажиллаж байсан мэргэжилтэй боловсон хүчин хот суурин

газарт олноор шилжин суурьших болсоноор хөдөөгийн хүн амын боловсролын түвшин өмнөхөөсөө буурах нөхцлийг бүрдүүлсэн гэж үзэх үндэстэй.

Хот, хөдөөгийн боловсролтой хүн амын хүйсийн харьцаа ерөнхийдөө улсын хэмжээнийхтэй ойролцоо байгааг зураг 3.3-аас үзэж болно.

Зураг 3.2 Арван таваас дээш настай боловсролтой хүн амын хүйсийн харьцаа, байршлаар, 2000 он



Хөдөөд дээд боловсролтой хүн амын хүйсийн харьцаа өндөр байгаа нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогтой холбоотой гэж үзэж байна.

3.3 Хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин, яс үндэсээр

Манай улс ард иргэдээ сурч боловсроход нь яс үндэсээр ялгаварлаж байгаагүй гэдгийг дээр тэмдэглэсэн билээ. Гэхдээ ястан үндэстнүүдийн бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин хоорондоо бага зэрэг ялгаатай байгааг хүснэгт 3.4-өөс үзэж болно. Улсын хэмжээний 15, түүнээс дээш настай бүх хүний 2.2 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байхад казах үндэстнүүд улсын дунджаас 0.2 пунктээр, дөрвөдүүд 0.6 пунктээр буриадууд 0.3 пунктээр тус тус илүү байгаа нь их зөрүү биш гэж үзэж байна. Харин 15, түүнээс дээш настай нийт хүн амд дээд боловсролтой хүний эзлэх хувийн жин улсын дунджаар 9.2 хувь байхад казах үндэстнийх улсын дунджаас 4.4 пунктээр доогуур байгаа нь гадаад шилжих хөдөлгөөнтэй холбоотой гэж үзэж байна. Харин баяд ястны дээд боловсролтой хүний эзлэх хувь улсын дунджаас 5.8 пунктээр дээгүүр байна. Улсын дунджаар 35-54 настай нийт хүн амын 15.3 хувь нь дээд боловсролтой байхад баяд ястных 22.0 хувь байгаа нь 1960-аад оны сүүлчээс 1980 –аад онуудад уг ястанууд дээд боловсрол олноороо эзэмшиж байсан нь нийт дүнгээрээ улсын дунджаас илүү гарах нөхцлийг бүрэлдүүлж байна.

Хүснэгт 3.4 Арван тав, түүнээс дээш настай хүн амын бичиг
 үсгийн мэдлэг, боловсролын түвшин, насны бүлэг,
 яс үндэсээр, 2000 он

| Насны бүлэг | Бичиг үсэг мэддэггүй | Бичиг үсэг мэддэг боловч боловсрол- | Бага | Бүрэн бус дунд | Бүрэн дунд, техник мэргэжил | ТМД дунд, бүрэн бус дээд | Дээд | Бүгд | |
|----------------|-------------------------|--|------|-------------------|-----------------------------------|--------------------------------|------|-------|-----------------|
| | | | | | | | | хувь | хүн амын тоо |
| Халх | | | | | | | | | |
| Бүгд | 2.1 | 3.1 | 15.4 | 30.2 | 30.6 | 9.2 | 9.4 | 100.0 | 1248288 |
| 15-24 | 2.2 | 2.8 | 19.4 | 37.0 | 33.4 | 2.1 | 3.1 | 100.0 | 411116 |
| 25-34 | 1.1 | 0.8 | 3.6 | 30.2 | 41.9 | 12.2 | 10.3 | 100.0 | 334260 |
| 35-54 | 1.1 | 1.5 | 12.3 | 28.4 | 26.0 | 15.0 | 15.7 | 100.0 | 359478 |
| 55 + | 6.9 | 12.8 | 39.2 | 14.9 | 8.1 | 8.4 | 9.7 | 100.0 | 143434 |
| Казах | | | | | | | | | |
| Бүгд | 2.4 | 4.2 | 28.4 | 30.2 | 22.6 | 7.5 | 4.8 | 100.0 | 59178 |
| 15-24 | 2.0 | 4.2 | 35.1 | 33.4 | 21.4 | 2.6 | 1.3 | 100.0 | 21169 |
| 25-34 | 1.2 | 1.5 | 14.1 | 36.5 | 31.7 | 9.8 | 5.2 | 100.0 | 15940 |
| 35-54 | 1.4 | 2.3 | 25.5 | 28.0 | 21.8 | 12.1 | 8.9 | 100.0 | 15125 |
| 55 + | 8.5 | 14.2 | 47.2 | 10.5 | 6.9 | 6.8 | 5.8 | 100.0 | 6944 |
| Дөрвөд | | | | | | | | | |
| Бүгд | 2.8 | 4.0 | 18.4 | 31.2 | 27.5 | 8.8 | 7.4 | 100.0 | 42152 |
| 15-24 | 2.9 | 3.8 | 23.1 | 36.4 | 29.6 | 1.9 | 2.3 | 100.0 | 13344 |
| 25-34 | 1.3 | 1.1 | 5.0 | 34.1 | 39.7 | 11.2 | 7.6 | 100.0 | 11006 |
| 35-54 | 1.5 | 2.0 | 15.5 | 30.7 | 23.9 | 14.5 | 11.9 | 100.0 | 12450 |
| 55 + | 8.4 | 14.7 | 41.2 | 12.9 | 5.6 | 7.7 | 9.4 | 100.0 | 5352 |
| Баяд | | | | | | | | | |
| Бүгд | 1.9 | 3.4 | 13.0 | 26.0 | 30.0 | 10.7 | 15.0 | 100.0 | 28204 |
| 15-24 | 2.2 | 3.0 | 18.6 | 34.1 | 36.9 | 2.1 | 3.1 | 100.0 | 7986 |
| 25-34 | 1.3 | 0.8 | 3.4 | 27.2 | 42.4 | 12.4 | 12.5 | 100.0 | 6413 |
| 35-54 | 0.9 | 1.3 | 8.5 | 25.4 | 25.7 | 16.2 | 22.0 | 100.0 | 9260 |
| 55 + | 4.1 | 12.3 | 25.7 | 11.4 | 9.1 | 12.3 | 25.1 | 100.0 | 4545 |
| Буриад | | | | | | | | | |
| Бүгд | 2.5 | 4.0 | 19.4 | 27.7 | 27.2 | 10.1 | 9.1 | 100.0 | 31991 |
| 15-24 | 2.5 | 3.9 | 26.0 | 32.7 | 29.9 | 2.0 | 2.9 | 100.0 | 10021 |
| 25-34 | 1.0 | 1.2 | 6.3 | 30.8 | 39.1 | 12.3 | 9.3 | 100.0 | 8516 |
| 35-54 | 1.4 | 2.0 | 15.6 | 26.3 | 22.7 | 17.0 | 15.0 | 100.0 | 9486 |
| 55 + | 8.7 | 15.0 | 39.7 | 12.1 | 5.4 | 9.1 | 10.1 | 100.0 | 3968 |
| Бусад | | | | | | | | | |
| Бүгд | 3.1 | 4.4 | 20.8 | 31.7 | 25.1 | 8.1 | 6.8 | 100.0 | 107750 |
| 15-24 | 3.2 | 4.2 | 26.0 | 37.9 | 24.9 | 1.6 | 2.1 | 100.0 | 34351 |
| 25-34 | 1.6 | 1.3 | 5.8 | 36.4 | 38.2 | 10.2 | 6.6 | 100.0 | 27039 |
| 35-54 | 1.5 | 2.1 | 18.0 | 30.2 | 23.4 | 13.9 | 11.0 | 100.0 | 31187 |
| 55 + | 8.9 | 15.4 | 41.2 | 12.2 | 5.9 | 7.3 | 9.2 | 100.0 | 15173 |

Арван тав, түүнээс дээш настай хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшинг хүйс, насны бүлгээр хавсралт 3.1, 3.2 –оос дэлгэрэнгүй үзэж болно.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого:
“Боловсрол, бичиг үсгийн мэдлэг”
сэдэвчилсэн судалгаа

БҮЛЭГ 3
ХҮН АМЫН БИЧИГ ҮСГИЙН
БОЛОВСРОЛЫН БАЙДАЛ
